



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,  
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,

Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.04.07

№

01/495

танай

-ны №

-т

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38, 30 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулан тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан зэрэг хангамжийн байгууллагын шатлал бүрд эмийн нэр төрөл, үнэ, цувралын мэдээлэл солилцох байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг үе шаттай хийж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.7-д эм хангамжийн байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн ил тод байдлыг хангах, цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулах үүргийг тус тус заасан.

Иймд хууль тогтоомжид заасны дагуу программ хөгжүүлэгч байгууллагатай хамтран цахим төлбөрийн баримтын систем "POS API 3.0"-д цувралын дугаар, дуусах огноо, тоо хэмжээ (ширхэг), стандарт код, худалдааны нэр, хэмжих нэгжийг илгээж, и-баримтад цувралын дугаар, дуусах огноог хэвлэх хөгжүүлэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор хийж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Заасан хугацаанд цахим төлбөрийн баримтын систем "POS API 3.0"-д хөгжүүлэлтийг хийж үйл ажиллагаанд нэвтрүүлээгүй тохиолдолд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу арга хэмжээ авахыг мэдэгдэж байна.

Хавсралт *2* хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *T. Адам* АЛТАНЦЭЦЭГ



1526 150462



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,  
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,  
Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.03.30 № 01/439

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хамтран ажиллах тухай**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23, 203, 2024 оны 38, 30 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь иргэд, эрүүл мэндийн байгууллагыг чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг тасралгүй, жигд хүртээмжтэй хангах зорилгоор төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулан эм хангамжийн байгууллагын шатлал бүрд эмийн нэр төрөл, үнэ, цувралын мэдээлэл солилцох байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн тогтолцооны хөгжүүлэлтийг үе шаттай хийж байна.

Эмийн зах зээлийн чанар аюулгүй байдлын хяналтыг цувралын дугаараар мөшгөх тогтолцоог бий болох зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвөөс эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын тогтолцоонд цахим төлбөрийн баримтын систем болох "POS API 3.0"-г нэвтрүүлсэн. Мөн эмийн бүртгэлийн Лайсмед программын эмийн мэдээллийг баркодоор лавлах сервис болон Улсын хилээр нэвтэрсэн эмийн цувралын дугаарыг баркодоор лавлах сервис (нэр: WS300186\_SearchServiceByBarcode), Бүх эмийн мэдээллийг лавлах сервис (WS300147\_GetAllDruglistingsInfo) -ийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д нээлттэй байршуулсан.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.13-т заасан Хангамжийн байгууллага энэ хуулийн 47.12-т заасан цахим мэдээллийн нэгдсэн санд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнийг тухай бүр байршуулах үүргийг хангах үүднээс эм хангамжийн байгууллагууд өөрсдийн борлуулалтын программд импортын эмийн орлого, зарлагыг ХУР системд байгаа Улсын хилээр нэвтэрсэн эмийн цувралын дугаарыг баркодоор лавлах сервис ашиглаж, цахим төлбөрийн баримтын системд цувралын дугаар хүчинтэй хугацааны мэдээллийг илгээх, иргэнд очих и-баримт дээр цувралын дугаар, хүчинтэй хугацааны мэдээллийг хэвлэх, мөн бүтээгдэхүүний нэршил дээр Бүх эмийн мэдээллийг лавлах сервис (WS300147\_GetAllDruglistingsInfo) -ийг ашиглаж дараах 4 талбарыг нэгтгэж илгээх шаардлагатай байна. Үүнд:

. 1526 100410

1. Худалдааны нэр,
2. Тун хэмжээ,
3. № (Савлалтын хэмжээ)
4. Үйлдвэрлэгч,

Жич: Улсын хилээр нэвтэрсэн эмийн цувралын дугаарыг баркодоор лавлах сервис (WS300147\_GetAllDruglistingsInfo) -ийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР) -ээс дуудахад төлбөргүй болсон болно.

Иймд 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор дээрх хөгжүүлэлтийг хийж, хамтран ажиллана уу.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *T. Davaa* ГАЛТАНЦЭЦЭГ

